

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**
/2023 оны IV улирал/

2023 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

1. Тус газарт 2023 оны IV улирлын байдлаар нийт 34 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн байна.

Үзүүлэлт	2022.01.01-12.23		2023.01.03-12.22	
	Тоо	Шийдвэрлэлтийн хувь	Тоо	Шийдвэрлэлтийн хувь
Ирсэн өргөдлийн тоо	24	100%	34	100%

2. Нийт ирсэн 34 өргөдлийг 7 албан хаагч хугацаанд нь 100% шийдвэрлэсэн. Газрын дарга болон Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргад өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар сар тутамд тайлан гарган, танилцуулан ажиллаж байна. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.

3. Тус газарт 1800-1200 тусгай дугаарын утаснаас ирсэн өргөдөл гомдол ирээгүй.

4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 05 хоног 00 цаг 17 минут байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар тухай бүр газрын хурлаар танилцуулж, НЗДТГ-ын Үйлчилгээний Нэгдсэн төвд улирал болон 7 хоног бүр өргөдөл гомдлын тайланг хугацаанд нь хүргүүлж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Д.БАТСҮХ

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

Т.ХАЛИУН



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ
/2023 оны IV улирал/**

2023 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

**Тус газарт 2023 оны IV улиралд ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн
шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдээ**

Д/д	Иргэн	Шийдвэрлэлтийн байдал
1	О.Хандам	Оюунтуяа овогтой Хандам миний бие хоёр хүүхдээ 2023 оны 1 дүгээр сарын 16-наас 06 дугаар сарын 01 хүртэл өөрийн биеэр хүргэж өгөх болсон тул ажлын цагыг өглөөний 09:00-18:00 болгон өөрчилж өгнө үү гэсэн хүсэлт гаргасан хэдий ч энгийн цагийн хуваарийн дагуу ажиллахаар хүүхдийнхээ хичээл сургуульд хүргэж өгөх асуудлыг гэр бүлийн хүрээнд зохицуулсан тул ажил эхлэх цаг 08:00, дуусах цаг 17:00 хэвээрээ үргэлжлүүлэхээр болов.
2	Т.Туул	Төмөрийн Туул миний бие 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдөр Япон улсад "Аялал жуулчлалын хүний нөөцийг чадавхжуулах ба тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх" сэдэвт сургалтад хамрагдах болсон тул цалинтай чөлөө олгож өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч төрийн албаны тухай хуулийн 61.1.7 дахь заалтыг үндэслэн чөлөө олгов.
3	Г.Дамдинсүрэн	Ганбаатарын Дамдинсүрэн миний бие тус газар 2023 оны 01 дүгээр сарын 16-нд ажилд орсон бөгөөд цаг үе болон гэр бүлийн хүндэтгэх шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй байна. Хүсэлтийг минь хүлээн авч шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч хөдөлмөрийн тухай хуулийн 79.1 дэх заалтын хүрээнд ажлаас чөлөөлсөн.
4	О.Одонтунгал аг	Олегийн Одонтунгалаг нь тус газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтэст Аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтнээр ажилладаг. Гэр бүлийн хамтаар Япон улсад урт хугацаанд амьдрах болсон тул ажлаас чөлөөлж өгнө үү. Мөн энэхүү өргөдлийг харгалзан ажлаас чөлөөлөгдөх тушаалыг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр гаргаж өгнө үү гэх хүсэлтийг хүлээн авч 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Б/22 дугаартай газрын даргын тушаалаар ажлаас чөлөөлөв.
5	Б.Жаргалан	Баярмагнай овогтой Жаргалан нь 2011 оноос мэргэжилтнээр ажиллаж байсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр амаржиж хүүтэй болсон тул хүүхэд асрах чөлөө олгож өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч 2023 оны 04 сарын 03 -ны өдрийн Б/26 дугаар тушаалаар шийдвэрлэсэн.
6	Т.Туул	Миний бие Төмөрийн Туул нь бодлогын хэрэгжилтийн хэлтэст гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтнээр ажилладаг. Хувийн шалтгааны улмаас цаашид тус газарт ажиллах боломжгүй болсон тул

		өргөдлийг минь хүлэн авч шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Газрын даргын Б/30 дугаар тушаалаар шийдвэрлэсэн.
7	М.Энхчимэг	Миний бие Миша овогтой Энхчимэг нь тус газарт мэдээллийн ажилтнаар ажилладаг бөгөөд 2023.04.11-2023.05.11 хүртэл хугацаанд хувийн шалтгааны улмаас цалингүй чөлөө хүсэж байна. Хүсэлтийг минь хүлээн авч шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Б/29 дугаар тушаалаар шийдвэрлэсэн.
8	Ц.Мөнхжаргал	Миний бие Ц.Мөнхжаргал нь тус газарт мэдээллийн ажилтан хийдэг бөгөөд МУИС-ийн оройн ангид суралцдаг. Мэргэжлийн хээрийн урт хугацааны дадлагад явах болсон, явж ирээд эргэн ажилдаа орно. Тиймээс хүсэлтийг минь хүлээн авч чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч газрын даргын 2023,04,21-ний өдрийн Б/31 дүгээр тушаалаар шийдвэрлэсэн.
9	Б.Азжаргал	СБД-н 10-р хороо 23-р хорооны оршин суугч байна. Манай байрны хойд талд 69-р цэцэрлэг байрладаг бөгөөд тус цэцэрлэгийн хашаанд 2 давхар тоосгон зочид буудал ажилладаг. Одоо удахгүй тус хашаанд нь мөн 234-р цэцэрлэгийн өргөтгөл баригдах гэж байгаа. Цэцэрлэгийн орчинд зочид буудал үйл ажиллагаа явуулаад согтуу иргэд цонхоороо бөөлжиж байхад бага насны хүүхдүүд хажуугаар нь цэцэрлэг рүүгээ орж байна шүү дээ. Тус зочид буудлын нураачих юм бол цэцэрлэгийн орчинд эвгүй дүр зураг харагдахгүй, цаашаага авто замын уулзвар хүртэл нээгдчих боломж байгаа. Мөн манай 23-р байрны баруун талд 2 метрийн зайд "Ноён пицца" гэх үйл ажиллагаа явуулдаг барилга байсан бөгөөд нэг давхар байсан бол тус нэг давхар дээрээ дахин нэмж 2 давхар болгочихсон оршин суугчдын эрх ашгийг зөрчөөд байгаа. Уг асуудлаар бид удаа дараа холбогдох байгууллагуудад нь өргөдөл гомдлоо өгдөг, ирж шалгадаг боловч арга хэмжээ авч өгөхгүй дийлэхгүй байна. Холбогдох харьяа байгууллагад нь уламжилж өгнө үү гэсэн гомдлыг хүлээн авч 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр гомдол гаргасан иргэнтэй 88117015 утсаар холбогдон тус газар нь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 захирамжаар олгохгүй болсон талаарх мэдээллийг өгч, тайлбарлаж хэлсэн. Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас тухайн дэн буудлын газар эзэмших болон өмчлөх эрхийн талаарх мэдээллийг лавлаж асуух талаар нэмэлт тайлбар, мэдээллийг өгсөн.
10	Г.Энхбаяр	https://www.tugch.com/5475/?fbclid=IwAR3Z3BRT_WFSddqI9Nw3riNMTs0g_eh_a0Jgj3oowzVix9FJuwP0g8TAiHA_aem_th_AboD0kGX-AjdEyaWEvLgRyhyuZwCXZr0TWhJeMEHwWY-XYYSw3tiL3U3PVQenBbffJQ&mibextid=Zxz2cZ . Энэхүү нийтлэлийг уншиж танилцан гадаадаас ирж буй жуулчид Монголыг их шүүмжилж байгаа болохоор , жуулчид ихээр хүлээж авдаг байгууллагууд энэхүү асуудлыг анхааралдаа авмаар байна гэсэн хүсэлтийг хүлээн авч 2023 оны 06 дугаар сарын 13, 15, 21-ний өдрүүдэд утсаар холбогдохоор гар

		<p>утас руу залгасан боловч одоог хүртэл холбогдохгүй байгаа тул программаар өргөдлийг хаав. Тус газар нь хариуцсан чиг үүргийн хүрээнд: Хотын аялал жуулчлалын харилцааг зохицуулах дүрэм, журам, стандартыг баталж, мөрдүүлнэ. Улаанбаатар хотын аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажилд инновацийг нэвтрүүлж, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүсчлэлийн дагуу түүх, соёлын дурсгалт газрууд болон аяллын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн хөгжүүлж, эргэлтэд оруулна. Салбарын хүний нөөцийг чадавхжуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. Аялагчдын боловсролыг дээшлүүлж, жуулчдын аюулгүй байдлыг хангана. Жуулчдад зориулсан олон улсын шинж чанартай урлаг соёл, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулна. Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилтод ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Цаашид өөрсдийн үйл ажиллагаанд хамаарах ажлуудыг сайжруулан ажиллаж, санал гомдлыг тусган аялал жуулчлалын салбарын байгууллагуудад зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажиллахаар шийдвэрлэсэн.</p>
11	Б.Туяа	<p>7-р сарын 6,4,8-ны өдрүүдэд Play time шоу арга хэмжээ болж байгаатай холбоотойгоор тухайн чиглэлд гэр рүүгээ явдаг иргэд маш олон цагаар түгжирч байгаад гомдол гаргаж байна. Тухайн 3 хоногт замын ачаалал ихсэж, шоунд ирсэн хүмүүс шороон замаар маш хурдтай давхиж хүн мөргөх эрсдэл өндөр байдаг. Шоу зохион байгуулж байгаа хүмүүс хариуцлагатай зохион байгуулмаар байна. Хиймлээр түгжрэл үүсгэж маш их бухимдал ачаалал үүсгэж иргэдийг хохироож байна. Зогсоолоо шийдэж чадахгүй юм бол яах гэж ийм олон зуун хүнд билетээ худалдаалдаг юм бэ. Маш их гомдолтой байна. Холбогдох байгууллагад нь уламжлан арга хэмжээ авч өгнө үү хэмээх гомдлыг хүлээн авч уг санал гомдлын дагуу "Амьд хөгжмийн наадам" ТББ байгууллага болон Нийслэлийн Аялал Жуулчлалын газар хамтран иргэдэд хохирол чирэгдэл учруулж буй асуудалд санал солилцон гаргасан шийдвэрийг утсаар холбогдон мэдээлэл хүргүүлж иргэний хувийн цахим хаягаар албан бичиг илгээж шийдвэрлэсэн.</p>
12	Ч.Баянжаргал	<p>БЗД-ийн 20 дугаар хороонд Playtime шоу жил бүр Монгол Шилтгээнд болж иргэдийн амгалан тайван байдал алдагдуулж байна. Тус шоу хотын төвөөс хол газар хийдэг болгосоор байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлэж өгнө үү гэсэн гомдлыг хүлээн авч тус иргэнлүү холболдож мэдээлэл хүргүүлж иргэний гомдлыг шийдвэрлэх гэсэн боловч би гомдол гаргаагүй гэсэн хариулт өгсөн тул хаасан.</p>
13	Т.Шинэхүү	<p>Тэрэлж дээр аялал жуулчлалын бүс гээд иргэдээс хураамж авдаг болсон байна. Автобустай иргэдээс хүн тус бүр 3000 төгрөгөөр тооцож авдаг бололтой байна. Жишээ нь 40 хүнтэй автобус гэхэд 120 000 төгрөг өгөх ёстой байтал, цагдаад нь хэдэн төгрөг өгөөд тал үнийг нь төлж байна. Энэ байдлыг анхааралдаа авч арга хэмжээ авна уу гэх хүсэлтийг хүлээн авч дээрх асуудлын хүрээнд Байгаль, орчин Аялал жуулчлалын газарт чиг үүргийн дагуу шалгаж хариу тайлбар өгч, арга</p>

		хэмжээ авах тухай мэдээллийг иргэнд хүргэсэн. Чиг үүрэгтэй тул Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь тухай асуудалд шийдвэр гаргах боломжгүй талаар утсаар иргэн Шинэхүүтэй холбогдож мэдээллийг өгөв. Мөн дээрх асуудлыг Байгаль орчин аялал жуулчлалын яамны албан ёсны мэйл хаягаар арга хэмжээ авч өгөх талаар Иргэн Шинэхүүгийн гомдлыг хүргүүлсэн. Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт нэвтрэх үйлчилгээний тариф-ийг Байгаль орчин Аялал жуулчлалын сайдын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн тушаалаар тогтоосон бөгөөд тухайн төлбөр хурамжийн албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа болон хувьдаа авч байгаа асуудлуудыг Авлигатай тэмцэх газарт мэдээллэн шалгуулах, Байгаль орчны Улсын байцаагчид хандах хэрэгтэй гэж шийдвэрлэсэн.
14	М.Энхчимэг	Миша овогтой Энхчимэг миний бие тус газрын жуулчин мэдээллийн төвд мэдээллийн ажилтнаар ажилладаг. Өөрийн хүсэлтээр 2023 оны 07 дугаар сарын 01-ний дотор ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй байна. Хүсэлтийг минь хүлээн авч шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч хөдөлмөрийн тухай хуулийн 79.1 дэх хэсгийг үндэслэн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ын өдрийн Б/42 дугаар тушаалаар ажлаас чөлөөлж шийдвэрлэв.
15	Б.Майцэцэг	Миний бие Б.Майцэцэг нь Улаанбаатар хот ХУД-ийн 16-р хорооны иргэн билээ. Миний бие 2023 оны 07-р сарын 04-ны өдрөөс 07-р сарын 12-ны өдөр хүртэл манай орноор аялах Бүгд найрамдах Солонгос улсын 11 жуулчинд хөтөч орчуулагчын ажил хийнэ. Бүгд найрамдах Солонгос улсын 11 иргэн мөн хөтөч миний бие нийт 12 хүний 2023 оны Наадмын нээлтийн тасалбар захиалж авах хүсэлтэй байгаа тул хүсэлтийг минь хүлээн авч туслалцаа үзүүлнэ үү гэсэн хүсэлтийн дагуу дараах хариуг хүргүүлсэн. “Үндэсний их баяр наадам үзэх гадаад жуулчдын тасалбар захиалгын хүсэлтийг 2023 оны 06 дугаар сарын 21-нээс 06 дугаар сарын 30-ны хооронд нийслэлийн Аялал жуулчлалын газар бичгээр болон цахимаар хүлээн авсан. Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын аялал жуулчлалын холбооны хамтарсан ажлын хэсэг 7 дугаар сарын 03,04-ны өдрүүдэд ажиллаж суудал хуваарилалтыг хийсэн. Энэ жил Шадар сайдын ажлын алба, жуулчдад зориулсан наадмын 1772 ширхэг тасалбар төлөвлөсөн бөгөөд нийт 189 жуулчны компанийн 8774 хүсэлтийн дагуу аль болох хүртээмжтэйгээр хуваарилан олгож байна. Иргэд болон жуулчны тур операторын компаниар бус хувийн шугамаар орж ирсэн жуулчдад билетийн тоо хязгаарлагдмал, хүрэлцээгүй байгаа тул хуваарилах боломжгүй байгаа талаарх мэдээллийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр иргэн Б.Майцэцэгтэй 99813510 утсаар холбогдож өгөв.”
16	Д.Ганхуяг	БЗД-ийн 20 дугаар хорооны иргэн байна. Play time 2023 урлагийн наадмыг зогсоолгох хүсэлтэй байна. Үер ус болоод нөхцөл байдал хүнд байхад энэ наадмыг зохион байгуулж байгааг ойлгохгүй байна. Тус наадмыг хэд хоногоор хойшлуулж өгөхийг хүсэж байна. Миний гомдлыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү гэсэн гомдлыг хүлээн авч “Плэйтайм” олон улсын хөгжмийн наадмыг “Амьд хөгжмийн наадам” ТББ-тай хамтран “Монгол шилтгээн цогцолбор”-т 2023 оны 07 дугаар сарын 06,07,08-ны өдрүүдэд 3 өдрийн турш зохион байгуулахаар төлөвлөгдсөн ч үерийн аюул, гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан 2023 оны 07 дугаар сарын 06, 07-ны өдрүүдийн арга хэмжээний хөтөлбөрийн хугацааг багасгаж тухайн өдрүүдэд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтсийн удирдлага, албан

		хаагчид байнгын хяналт тавьж Нийслэлийн Онцгой комиссыг мэдээллээр хангаж ажилласан бөгөөд үерийн аюулаас урьдчилан сэргийлж иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах зорилгоор 2023 оны 07 дугаар сарын 08-ны арга хэмжээг цуцлах арга хэмжээг авч шийдвэрлэсэн.
17	Э.Мөнхзул	Тус газрын бодлогын баримт бичгийн тайлан сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Мөнхзул би ажил их байсантай холбоотой ажлын 10 хоног дутуу ажилдаа орж ирсэн. Хамаатны ахын бие муудсан тул 2023 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд ажлын 3 хоногийн чөлөөг дутуу үлдсэн амралтын хоногоос тооцуулан авах хүсэлтэй байна. тооцож өгөн үү гэсэн хүсэлтийн дагуу чөлөөг олгож шийдвэрлэсэн.
18	С.Баатарсүрэн	Би тэрэлжид байрлах Экстрэмэ монголиа гэх байгууллагын буруутай үйл ажиллагаанаас болоод 8 дугаар сарын 13-ний өдөр хүүхэдтэйгээ цуг бэртчихээд байна. Тус газар нь чанарын шаардлага хангаагүй газар байна. Энэ байгууллагын тусгай зөвшөөрлийг шалгуулж үйл ажиллагааг нь зогсоолгомоор байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу “Экстрим Монголиа” ХХК-ийн Булагтай амралтын экстрим тоглоомын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоох болсныг иргэнд 99000625 дугаар утсаар мэдэгдсэн.
19	С.Гантөмөр	Налайх дүүрэгт байрлах "Бугат" гэх зочид буудалд гомдолтой байна. Заавал барьцаа мөнгө байршуулж байж үйлчилнэ гэсэн шаардлага тавьж байна. Уг асуудалд гомдолтой байна. Холбогдох харьяа байгууллагад нь уламжилж өгнө үү гэсэн гомдлыг судлахын тулд тус иргэнээс асуудлыг тодруулахаар ажлын газрын 70148687, өөрийн гар утас 88087730 дугаараас тус тус 5 таван удаа өнгөрсөн ажлын өдчүүдэд залгасан. Гэвч иргэн маань утсаа авсангүй. Иргэд зочид буудлын үйлчилгээ авахын тулд урьдчилгаа төлбөр байршуулдаг олон улсын жишиг байдаг болно.
20	Т.Батдорж	Түвшинжаргал овогтой Батдорж миний бие түр орон тоон дээр ажилладаг. Өөрийн хүсэлтээр 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй байгааг хүлээн авна уу гэсэн хүсэлтийг хүлээн авч газрын даргын 2023 оны Б/55 тушаалаар ажлаас чөлөөлсөн.
21	Н.Алтанзаяа	Миний бие Нармандахын Алтанзаяа нь тус газарт Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтнээр ажилладаг. бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс жирэмсний болон амаржсаны амралтаа авах хүсэлтэй тул холбогдох тушаал шийдвэрийг гаргаж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч жирэмсний болон амаржсаны амралт олгохоор шийдвэрлэв.
22	Л.Оюунхорлоо	Л.Оюунхорлоо миний бие өөр байгууллагад шилжин ажиллах болсон тул ажлаас чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Б/65 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөв.
23	Б.Энхцэцэг	Тус газрын Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн Батдэлгэрийн Энхцэцэг миний бие хүү А. Дөлгөөнмөрөнг цэцэрлэгт өглөө, оройд өгч авахад ажлын цагт багтахгүй байгаа тул Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтын хүрээнд орой 16:30 цагт тарах цагийн зохицуулалт хийж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хүрээнд ажлын цагийн зохицуулалтыг ERP.ulaanbaatar.mn системд цагийн хуваарийг оруулж 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс

		2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг 07:30-16:30 цагийн хооронд ажиллахаар тохируулав.
24	Б.Цолмонгэрэл	Батбаатар овогтой Цолмонгэрэл нь тус газрын Бодлого хэрэгжилтийн хэлтэст Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтнээр ажилладаг. Хичээлийн шинэ жил эхэлсэн болон замын хөдөлгөөний ачааллаас үүдэн ажлаас хоцрох нөхцөл үүсч байгаатай холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 3 дахь заалтыг баримтлан ажлын цагийн зохицуулалт хийж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хүрээнд ажлын цагийн зохицуулалтыг ERP.ulaanbaatar.mn системд цагийн хуваарийг оруулж 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг 08:30-17:30 цагийн хооронд ажиллахаар тохируулав.
25	Д.Сайханчимэг	Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж өглөөний 08:30 цагаас ажил эхлэх цагийг бүртгэж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хүрээнд ажлын цагийн зохицуулалтыг ERP.ulaanbaatar.mn системд цагийн хуваарийг оруулж 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг 08:30-17:30 цагийн хооронд ажиллахаар тохируулав.
26	Б.Отгонбилэг	Баатар овогтой Отгонбилэг миний бие тус газрын Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтнээр ажилладаг бөгөөд хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан өөрийн охин О. Дөлгөөнсаруулыг сургуульд өглөө хүргэж өгдөг тул хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хүрээнд цагийн зохицуулалт хийж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хүрээнд ажлын цагийн зохицуулалтыг ERP.ulaanbaatar.mn системд цагийн хуваарийг оруулж 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг 08:30-17:30 цагийн хооронд ажиллахаар тохируулав.
27	С.Туул	Сайндорж овогтой Туул миний бие тус газарт Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтнээр ажилладаг бөгөөд хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан хүүхдээ өглөө хичээлд нь хүргэж өгөх шаардлагатай байгаа тул Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын дагуу ажлын цагийн зохицуулалт хийж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хүрээнд ажлын цагийн зохицуулалтыг ERP.ulaanbaatar.mn системд цагийн хуваарийг оруулж 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг 08:30-17:30 цагийн хооронд ажиллахаар тохируулав.
28	Ч.Энх-Отгон	Чулуунбаатар овогтой Энх-Отгон миний бие нь 2011 оноос эхлэн арьсны Псиораз гэх оноштой өвчнөөр өвчлөөд 12 жил болж байгаа билээ. Жил ирэх тусам энэ өвчний гарах талбай нь ихсэн, томорч, зовиур нь ихсэж байгаа болохоор зайлшгүй эмчлүүлэх шаардлага үүсээд БНСУ-д сурч, амьдардаг найзаараа зуучлуулан тэнд эмчилгээнд орох боломж гарсан тул миний эрүүл мэндийн шалтгааныг ойлгож 2023 оны 10 сарын 23-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай цалинтай чөлөө олгож өгөөч хэмээн хичээнгүйлэн хүсэж байна гэсэн хүсэлтийг хүлээн авч газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Б/69 дүгээр тушаалаар шийдвэрлэсэн

29	В.Батчимэг	Ванчиндоржийн Батчимэг миний бие нь МУБИС-ийн Боловсрол судлалын сургуульд "Боловсролын удирдахуй" чиглэлээр магистрантурт сурч байгаа бөгөөд 2023 оны 12 дугаар сард диплом хамгаалалт болон хичээлтэй тул 2023 оны 10 дугаар сарын 26-аас 30-ны өдрийг хүртэл богиносгосон цагаар ажиллахыг дэмжиж, сурах боломжоор хангаж өгөхийг хүсье гэсэн хүсэлтийг хүлээн авч суралцах хугацааны чөлөөг газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний Б//71 дугаартай тушаалаар олгов.
30	Б.Мичидмаа	Миний бие Баттөмөр овогтой Мичидмаа нь тус газарт 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Жуулчны мэдээллийн төвүүд хариуцсан менежер албан тушаалд томилогдож ажилласан. Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн 99.2 дахь заалтын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн ээлжийн амралтыг биеэр эдлэх хүсэлтэй байгаа тул хүлээн авна уу гэсэн хүсэлтийг хүлээн авч 2023 оны 05дугаар сарын 23-наас 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх ээлжийн амралтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 99.2 дахь заалтын хүрээнд олгохоор болов. Ээлжийн амралтыг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн биеэр эдлүүлэхээр мэдэгдэх хуудсыг өгсөн.
31	Ш.Ундармаа	Миний бие тус газарт Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байгаад 2022 онд хүүхэд асрах чөлөө авсан. Хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд бүтцийн өөрчлөлт хийж Хүний нөөц хариуцсан мэргэжилтнээр томилсон. Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч байгаа бөгөөд хуулийн дагуу хашиж байсан албан тушаалд минь томилж өгөхийг хүсье гэсэн хүсэлтийг хүлээн авч газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн Б/72 дугаар тушаалаар ажилд үргэлжлүүлэн томилсон.
32	Д.Уранцэцэг	Миний бие Дорж овогтой Уранцэцэг нь "Дун Өргөө" ХХК-ны Өргөө зочид буудалд 2018 оны 02 дугаар сараас эхлэн 2023 оны 11 сарын 01-н хүртэл ресепшинээр тасралтгүй 6 жил ажилласан. 2023.11.01-нд ажлын байрны дарамт шахалтаас болж цаашид ажиллах боломжгүй болсон тул өөрийн хүсэлтээр ажлаас халагдах өргөдлөө өгсөн. Өргөө зочид буудал ихэнхидээ гадаад зочид хүлээн авдаг. Сүүлийн 3 жил хамгаалалтын ажилтангүй ресепшин нь ганцаараа хонож ажилладаг. Гадаад зочдын аюулгүй байдал алдагддаг. Мөн ариун цэвэр бүр байхгүй. Ресторан нь үйлчлэгчгүй бөгөөд зохион байгуулагч нь ариун цэврийн өрөөгөө, бармен зөөгч нар нь рестораны шалаа цэвэрлэдэг. Мөн буудлын өрөөний үйлчлэгч ганцаараа арван өрөө цэвэрлээд, угаалгаа хийдэг. Угаагч гэж тусдаа байдаггүй. Иймээс зочид буудлын стандартын дагуу үйлчилгээ явуулдаг болгох талаас нь хяналт шалгалт хийж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч Монгол Улсын стандарт "Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008"-ийн хэрэгжилтийг шалгах аар Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Мөнхзул, Жуулчны аюулгүй байдал, үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн Д.Оюун-Эрдэнэ нар менежер Г.Наранчимэгийг байлцуулан шалгалт хийж ДУН ӨРГӨӨ ХХК-ийн "ӨРГӨӨ" зочид буудлын гүйцэтгэх захирал Г.Зуундарьд албан бичгээр шаардлага хүргүүлсэн. Энэ тухай иргэн Д.Уранцэцэгт 91009888 дугаар утсаар хариуг өгсөн.

33	Ч.Энх-Отгон	Чулуунбаатар овогтой Энх-Отгон миний бие эрүүл мэндийн шалтгаанаар үргэлжлүүлэн эмчлүүлэх шаардлага гараад байгаа тул ажлаас минь цалингүй 1 сарын чөлөө олгож өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч, газрын даргын Б/75 дугаарын тушаалаар шийдвэрлэсэн.
34	Т.Халиун	Түмэнбаяр овогтой Халиун миний бие тус газарт Архив, бичиг хэргийн эрхлэгчээр ажилладаг. 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр нөхрийн гэр бүлд ажил явдал гарсан тул газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А66 тушаалын 11.5.3 дахь заалтын дагуу чөлөө олгож өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Хөдөлмөрийн дотоод журмын 11.5.3 дахь заалтын дагуу чөлөө олгосон болно.

--о0о--